



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 19 оны 05 дугаар
сарын 10 -ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн түвшинд гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.


3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар /хошууч генерал Т.Бадрал/-т үүрэг болгосугай.

Монгол Улсын Шадар Сайд



Ө.ЭНХТҮВШИН

0000079



**ГАМШГААС ХАМГААЛАХ САЙН ДУРЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
САНХҮҮЖҮҮЛЭХ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн /цаашид "сайн дурын хэсэг" гэх/ үйл ажиллагааг санхүүжүүлэх, урамшуулал олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Сайн дурын хэсгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал, урамшууллыг зөвхөн сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан сайн дурын хэсэгт олгоно.

Хоёр. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааны зардал

2.1. Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааны зардалд дараах зардал багтана. Үүнд:

2.1.1. гамшгийн үеийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах багаж хэрэгсэл, хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хувцас, шатахуунаар хангах;

2.1.2. сайн дурын хэсгийг сургаж бэлтгэх;

2.1.3. гамшгийн голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн хугацаанд олгох томилолт;

2.1.4. урамшуулал.

2.2. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааны зардлыг сум, дүүргийн Засаг дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ.

**Гурав. Сайн дурын хэсгийн ажилтанд
олгох томилолт, урамшуулал**

3.1. Гамшгийн голомтын бүсэд ажилласан сайн дурын хэсгийн ажилтанд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нэгэн адил томилолтын зардлыг үүрэг гүйцэтгэсэн хоногоор тооцож олгоно.

3.2. Энэхүү журмын 2.1.1, 2.1.3-т заасан зардлыг Засгийн газрын 2019 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журам"-д зааснаар олгоно.

3.3. Сайн дурын хэсгийн ажилтанд олгох урамшуулал нь дараах хэлбэртэй байна.

3.1.1. мөнгөн урамшуулал олгох;

3.1.2. төрийн болон төрийн бус байгууллагуудын шагналаар шагнах;

3.1.3. аялал, сувилал, эмчилгээнд хамруулах;

3.4. Сайн дурын хэсгийн ажилтанд томилолт, урамшуулал олгоход шаардагдах материалыг тухайн орон нутгийн Засаг даргын тамгын газрын сайн дурын хэсгийг хариуцахаар томилогдсон албан тушаалтан бүрдүүлнэ.

Дөрөв. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх

4.1. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д заасны дагуу бүрдүүлсэн хөрөнгөнөөс санхүүжүүлнэ.

4.2. Сайн дурын хэсгийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сум, дүүргийн Засаг дарга баталж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнд шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр санхүүжүүлнэ.

Тав. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд тавигдах шаардлага

5.1. Сайн дурын хэсгийн үйл ажиллагааг дор дурдсан шаардлагыг харгалзан санхүүжүүлнэ:

5.1.1. Сайн дурын хэсгийн өмнөх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал;

5.1.2. Сайн дурын хэсэг нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлан, мэдээ ирүүлсэн байдал;

5.1.3. Сайн дурын хэсгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсон тоо, ажлын үр дүн.